

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2025 – 05 САР | ДУГААР 78

ГАРЧИГ

2–5 Бодлогын нийтлэл

6–8 Зохицуулалтын мэдээ

9–10 Ярилцлага

11–12 Тогтвортой санхүүжилт

13 Компанийн засаглал,
комплайнс

14–15 Финтек ба регтек

16–23 Судлаачийн индэр

24–25 Санхүүгийн салбар дах
хиймэл оюун ухааны
хэрэглээ

26–27 Олон улсын зах зээлийн
мэдээ

28 Олон улсын хөрөнгийн
зах зээлийн индекс

ШИЛЖИЛТИЙН БОНД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ дэлхийн зах зээл дээр салбартаа нэр хүндтэй платформуудыг танилцуулахаар бэлтгэлээ. Peer-to-peer зээл нь зээлдэгч болон хөрөнгө оруулагчийг шууд холбож уламжлалт банкны зуучлалгүйгээр гүйлгээ хийх боломжийг олгодгоороо онцлог юм. Энэхүү шинэлэг зээлийн арга нь зээлдэгчдэд бага хүүгээр зээл авах мөн хөрөнгө оруулагчдад өндөр өгөөж хүртэх боломжийг олгодог. Zopa болон Prosper зэрэг платформууд анх 2005 онд бий болсноос хойш P2P зээлийн үйлчилгээ эрчимтэй хөгжиж, зах зээлийн өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахын тулд цар хүрээгээ өргөжүүлсээр байна. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.



10. Peerform (АНУ)



Гүйцэтгэх захирал: Mikael Rapaport
Төв байр: Нью-Йорк, АНУ

2010 онд Уолл Стритийн санхүүгийн мэргэжилтнүүдийн үүсгэн байгуулсан Peerform нь зээл авахыг хүссэн зээлдэгчдийг Америкийн хөрөнгө оруулагчидтай холбодог P2P зээлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь голчлон өрийг нэгтгэх болон кредит картын өрийг дахин санхүүжүүлэх зорилготой зээлдэгчдэд чиглэдэг. Peerform-ийн боловсруулсан Loan Analyzer нэртэй өвөрмөц алгоритм нь уламжлалт зээлийн онооноос гадуур зээлдэгчдийг үнэлж, хөрөнгө оруулагчдад өөр өөр эрсдэл-өгөөжийн түвшин бүхий зээлийн зэрэглэл үүсгэдэг. 4,000 – 25,000 ам.долларын хооронд 36 – 60 сарын хугацаатай зээл санал болгодог.




ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Зээлжих зэрэглэл

Credit rating

Хөндлөнгийн байгууллагаас санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа болон багцын чанарт дүн шинжилгээ хийх, зэрэглэл тогтоох үйл ажиллагаа бөгөөд энэ нь компани, эсхүл Засгийн газрын зээлээ эргэн төлөх чадварын үзүүлэлт болдог.



Зээлийн ангилал

Loan classification

Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журмын дагуу тогтоосон хугацаанд зээлийн багцыг хугацааны болон чанарын хүчин зүйлийг тооцон учирч болзошгүй алдагдлаас хамгаалах, зээлийн эрсдэлийн сан байгуулах зорилгоор ангилах үйл ажиллагаа юм.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбар нь зөвхөн барилга, орон сууц худалдах, түрээслэх үйлчилгээ үзүүлээд зогсохгүй улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих олон талын чухал ач холбогдолтой салбар юм. Жишээлбэл үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарыг бодлогоор дэмжсэнээр дараах байдлаар эдийн засагт нөлөөлдөг. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн гүйлгээг нэмэгдүүлснээр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлөх;
- Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, үнэлгээчин, даатгагч, барилгын ажилтан гэх мэт ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх;
- Ипотекийн зээл, барьцаат хөрөнгийн санхүүжилт, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн эрэлтэд нөлөөлж, санхүүгийн урсгалыг идэвхжүүлэн, санхүүгийн зах зээлийн өсөлтөд нөлөө үзүүлэх;
- Зөв үнэлгээ, судалгаанд үндэслэн худалдан авалт хийх нь хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалж, эдийн засгийн үр ашигтай шийдвэр гаргахад туслах;
- Хүн амын суурьшлын бүтэц, хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж, дэд бүтэц, нийтийн үйлчилгээний хүрэлцээг тодорхойлох суурь мэдээлэл болох;
- Албан ёсны зуучлалын байгууллагуудаар үйлчлүүлснээр үл хөдлөх хөрөнгийн салбарын ил тод байдал сайжирч, далд эдийн засаг буурах гэх мэт.

Тэгвэл нөгөө талаар Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь үл хөдлөх эд хөрөнгийн салбарыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй, тус зах зээлд их хэмжээний мөнгөн гүйлгээ, бэлэн мөнгө эргэлддэг, хууль бус орлогын гарал үүслийг далдлах боломж ихтэй гэж үздэг тул гишүүн орнуудад энэ салбарт эрсдэлд суурилсан хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар зөвлөмжүүдийг өгдөг.

Тухайлбал ФАТФ-аас Монгол улсад энэ салбар нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх магадлал өндөр байгааг анхааруулж үл хөдлөх хөрөнгийн салбарын хяналт, ил тод байдлыг сайжруулах шаардлагатайг онцолсон байдаг.

Манай улсын хувьд анхны үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага 2005 оноос албан ёсоор байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өдгөө 20 орчим

жилийн хөгжлийн түүхтэй шинэ салбаруудын нэг юм. ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу тус салбарыг манай улс 2020 онд төрийн буюу Санхүүгийн зохицуулах хорооны хяналт зохицуулалтад хамруулснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн байна.

Дээрх зохицуулалтыг хэрэгжиж эхлэхээс өмнө манай улсад 6,728 хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий газарт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн байсныг хүчингүй болгож, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оноос эхлэн Санхүүгийн зохицуулах хорооноос олгож эхэлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос нийт 365 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 63 хуулийн этгээдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бөгөөд 2025 оны I улирлын байдлаар 302 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага 319 брокер, 1,198 агенттайгаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Засгийн газраас Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор бүсчилсэн хөгжлийн бодлого баримталж дагуул хотуудын хөгжлийг дэмжих, орон сууцжуулалтыг нэмэгдүүлэх, ипотекийн зээлд иргэдийг үргэлжлүүлэн хамруулах гэх мэт шат дараалсан олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд барилгын салбар хурдацтай хөгжиж, орон сууцны эрэлт нийлүүлэлт тогтмол өссөөр байна.

Үүний нөлөөгөөр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын тоо болон зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх иргэн, хуулийн этгээдүүдийн тоо ч мөн адил өсөж байгаа бөгөөд 2024 онд зуучлалын байгууллагаар үйлчлүүлсэн харилцагчдын тоо 23,000-д хүрсэн байна. Мөн орон нутагт орон сууцны эрэлт, нийлүүлэлт нэмэгдсэнээр сүүлийн хагас жилийн хугацаанд Орхон аймагт 3, Дархан-Уул аймагт 1 хуулийн этгээдэд тус тус үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна.

Зохицуулалтын салбар хурдацтай хөгжихийн хэрээр салбарын стандартчиллыг тодорхойлох, мэргэжлийн шалгуурыг тогтоох, салбарын оролцогчдыг чадавхжуулах болон иргэд, олон нийтийг санхүүгийн залилан, луйвар, гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх ажлуудыг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлага тулгарч, Санхүүгийн зохицуулах хорооноос дараах зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ыг шинэчлэн баталлаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос гадаадын 12 улс (ОХУ, БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Сингапур, Хонг-Конг, Солонгос, Араб, Нидерланд, Бразил, Турк)-ын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын бодлого зохицуулалт, хууль эрх зүйн орчны судалгааг хийсний үндсэн дээр зохицуулалтын салбарын мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, эрх бүхий албан тушаалтан болон холбогдох ажилтнуудад тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх талаар мэргэжлийн холбоо болон зохицуулалтын байгууллагуудын саналыг авснаар Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 648 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, мөрдүүлж байна.

Тус журмаар зуучлалын байгууллагын холбогдох ажилтан (агент, эсхүл борлуулалтын ажилтан)-д нийтлэг шаардлагаас гадна Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангаж ажиллах шалгуурыг тавьсан. Үүнд:

Хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

Татварын албанд хувь хүний орлогын албан татварын тайланг тайлагнаж, татварын өр төлбөргүй байх;

Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй байх;

Эрүүгийн хуульд заасан залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн эсрэг гэмт хэргүүдэд холбогдоогүй байх. Эдгээр шаардлагыг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас гадна агент, эсхүл борлуулалтын ажилтанд тавигдсан.

Мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, ёс зүйтэй, санхүүгийн сахилга баттай мэргэжилтнүүдийг зохицуулалтын салбарт ажиллуулах, ингэснээр иргэд, үйлчлүүлэгчдийн эрх

ашгийг хамгаалах, санхүүгийн залилан, луйврын хохирогч болохоос урьдчилан сэргийлэх алхам болсон.

Нэр бүхий 81 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалт хийлээ.

Санхүүгийн зохицуулах хороонд иргэдээс ирүүлдэг өргөдөл гомдлуудын дийлэнх хувийг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын агентын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлдэг тул шинэчилсэн “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрүүдэд нэр бүхий 81 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Дээрх шалгалтаар зуучлалын байгууллагуудын хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтан, брокер, агентын бүртгэлийг тулган баталгаажуулж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулан, холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА:

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын хөгжлийн чиг хандлага нь зах зээлийн эрэлт хэрэгцээ, технологийн дэвшил, хууль эрх зүйн шинэчлэл, хэрэглэгчийн зан төлөвийн өөрчлөлт гээд олон хүчин зүйлээс хамаардаг. Монгол Улсын хувьд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт дараах чиг хандлага зонхилж байна. Үүнд:

Хиймэл оюун ухаан, Big Data, автомат үнэлгээний систем, виртуал аялал зэрэг технологиуд хэрэглээнд нэвтэрч эхэлсэн бөгөөд онлайн платформ, гар утасны аппликейшн ашиглан үл хөдлөх эд хөрөнгө зуучлах, харилцагчтай холбогдох боломж нэмэгдэж байна. Монголд ч зарим томоохон зуучлалын компаниуд чатбот, AI зөвлөгөө, 3D үйлчилгээг туршиж эхэлсэн байна.

Хэрэглэгчид үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой аливаа залилан, луйврын хохирогч болохоос урьдчилан сэргийлэхийн тулд тусгай зөвшөөрөлтэй, мэргэжлийн, баталгаатай

үйлчилгээг зуучлагчаар дамжуулах авах хандлага нэмэгдэж, тэр хэрээр мэргэшсэн зуучлалын ажилтны эрэлт өсөж байна.

Байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай ногоон хорооллууд, барилга байгууламжийн эрэлт нэмэгдэж, зуучлагч нарт зөвхөн худалдаан дээр анхаарахаас илүүтэйгээр харилцагчид энэ чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, үнэлгээ хийх ур чадвар эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.

Real estate crowdfunding болон REIT (Real Estate Investment Trusts) зэрэг шинэ хэлбэрийн хөрөнгө оруулалт Монголд хөгжиж эхэлж байгаа бөгөөд энэ нь иргэдэд бага дүнтэй хөрөнгөөр үл хөдлөх хөрөнгийн зах зээлд оролцох, ногдол ашиг хэлбэрээр орлого олох боломжийг эрэлхийлж байна.

Зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, түрээслэхэд зуучлах бус үл хөдлөх хөрөнгийн менежмент хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ зэргийг хамарсан цогц үйлчилгээний эрэлт өсөж, хэрэглэгч төвтэй бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэх хандлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос дээр дурдсан хөгжлийн чиг хандлагад суурилан зохицуулалтын салбарын мэргэжлийн холбоо болон Монголын үл хөдлөх эд хөрөнгө удирдлагын академитай хамтран үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, хариуцлагажуулах ажлын хүрээнд дараах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчийн ажил мэргэжлийн стандартыг батлуулав.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Ажил, мэргэжлийн жагсаалтад “Үл хөдлөх хөрөнгийн агент, брокер” гэсэн хоёр мэргэжлийг олон улсын аргачлалын дагуу бүртгүүлж, мэргэжлийн индексстэй болсон. Ингэснээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агентын эзэмшсэн ур чадвар, мэдлэг, дадал, ажил гүйцэтгэх чадамжийг ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэшлийн үндэсний хүрээ, мэргэшлийн дагуу үнэлж тодорхойлох, баталгаажуулах боломжтой болж нийгмийн байр сууриа баталгаажуулах, ажил олгогчид холбогдох стандартын дагуу шаардлага тавих гэх мэт давуу талууд үүссэн.



“Real estate investment” болон “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын агентын эрх олгох сургалтын гарын авлага” хэвлэгдлээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын үл хөдлөх хөрөнгө удирдлагын академитай хамтран “Real estate investment” болон “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын агентын эрх олгох сургалтын гарын авлага”-ыг боловсруулж, редакторлан хэвлэн нийтлүүлээ.



Үл хөдлөхийн менежментээр мэргэшсэн бизнесийн удирдлагын магистрын зэрэг олгох хөтөлбөр хэрэгжиж эхэллээ.

Санхүү эдийн засгийн их сургууль нь 2024 онд “Үл хөдлөх хөрөнгийн салбараар мэргэшсэн Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөр”-ийн дагуу анхны магистрын зэрэг

олгох элсэлтээ авсан бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт олон жил ажилласан мэдлэг туршлагатай оролцогчдыг хөтөлбөртөө хамруулж, ахисан түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэх ажил амжилттай эхэлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын “Ногоон реалтор”-уудыг бэлтгэж байна.

Барилгын салбар нь дэлхийн эдийн засгийн ойролцоогоор 13%-ийг, дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 30 орчим хувийг эзэлдэг гэсэн судалгаа байдаг. Иймд ногоон барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нь барилга байгууламжийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах, нөөц баялгийг илүү үр ашигтай зарцуулах боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг. Сүүлийн жилүүдэд үл хөдлөх хөрөнгийн салбарт “Ногоон барилга” гэх чиг хандлага томоохон байр суурийг эзлэх болсон бөгөөд үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтнүүд ч энэ талаар зөв ойлголт, мэдлэг мэдээлэлтэй байх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Иймд Шинжлэх ухаан технологийн их сургуулиас “Ногоон реалтор” хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, салбарын оролцогчдод цогц мэдлэг олгож эхэлсэн.

Монгол Улсад үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын мэргэжлийн оролцогчдыг чадавхыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахын тулд Санхүүгийн зохицуулах хорооноос дараах зорилтуудыг тавин ажиллаж байна. Үүнд:

- Зохицуулалтын салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Тогтвортой, ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх;
- Санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бодлогоор дэмжих;
- Санхүүгийн боловсролыг хүртээмжтэйгээр нэмэгдүүлэх;
- Салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх гэх зэрэг болно.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ДААТГАЛЫН САЛБАРТ ЗАЛИЛАНГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗАХ ЗЭЭЛ ДЭХ СӨРӨГ НӨЛӨӨГ БАГАСГАХ СЭДВЭЭР ХЭЛЭЛЦЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо, Монголын даатгалын зах зээлийн холбоо хамтран “Зах зээлийн эрүүл хөгжлийг дэмжих: Залилангаас сэргийлэх цогц тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтыг Хонконг, Сингапур дахь IBNR Management Consulting компанийн Ази тивийг хариуцсан захирал ноён Рудольф Фрай удирдан явуулсан бөгөөд сургалтад даатгалын салбарын удирдлагууд, нөхөн төлбөрийн албаны мэргэжилтнүүд хамрагдлаа.

IBNR Management Consulting компанийн Ази тивийг хариуцсан захирал Рудольф Фрай “Залилангийн эрсдэл нь даатгалын компанийн ашигт ажиллагаа, өрсөлдөх чадварыг бууруулах, нөхөн төлбөрийн хугацааг сунгах, гэрээний нөхцөлүүдийг хэт төвөгтэй болгох, зарим даатгалын бүтээгдэхүүний үнийг өсгөх зэргээр нийт зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг” талаар сургалтын үеэр онцлон дурдсан юм.

Сургалтаар даатгалын залилангийн өнөөгийн нөхцөл байдал, зах зээлд нөлөөлөх сөрөг нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох аргачлал бүхий цогц тогтолцоог бүрдүүлэх, үүнд салбарын бүх оролцогчдын үүрэг оролцоо чухал талаар иж бүрэн мэдлэгийг олгосон юм.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц Олон Улсын Санхүүгийн Корпорацийн төлөөлөгчдийг хүлээн авч



уулзлаа. Уулзалтад Зүүн Ази ба Номхон Далайн Санхүүгийн салбарын бүсийн менежер Андрес Гомез, Монгол дахь суурин төлөөлөгч Маттьё Лё Блан, хөрөнгө оруулалтын ахлах ажилтан Руйжинг Лин, Жанчян Хуан, Ажлын албаны дарга Б.Итгэлсүрэн, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нарын албаны хүмүүс байлцлаа.

Уулзалтаар Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс банкнаас бусад санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажлуудын талаар мэдээлэл өгч, Олон Улсын Санхүүгийн корпорацитай хамтран ажиллах шинэ боломжуудын талаар санал солилцлоо.

Тодруулбал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Даатгалын тухай хууль батлагдсанаас хойш 20 гаруй жил өнгөрсөн боловч энэ хугацаанд бодлогын томоохон өөрчлөлт, шинэчлэлүүд эдгээр хуульд ороогүй байна. Үүнтэй холбоотойгоор эдгээр салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр анхаарч ажиллаж буйгаа дурдлаа. Мөн банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй ажлууд, тэр дундаа банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа, суудлын автомашин худалдан авах хэрэглээний зээлийн зээл-үнэлгээний харьцаанд оруулсан өөрчлөлт, мөн банк бус санхүүгийн байгууллагуудын эрсдэл даах болон төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор итгэлцлийн үйлчилгээ, бонд болон бусдаас татан төвлөрүүлэх бусад эх үүсвэрийн зохистой харьцааг шинэчлэн тогтоосон талаар мэдээлэл хүргэсэн юм.

Түүнчлэн, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өнгөрсөн оны тавдугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон талаар, тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагаас Монгол Улсад бонд гаргах эрх зүйн орчин бүрдсэн талаар, мөн Санхүүгийн зохицуулах хорооноос бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлууд, ТОП–100 аж ахуйн нэгжүүдэд бонд гаргахыг дэмжих, татварын орчинд орсон өөрчлөлтүүд зэрэг бодлого зохицуулалтын арга хэмжээнүүдийн талаар танилцууллаа.

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХАМТАРСАН ШАЛГАЛТЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооноос Нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр дээр барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд энэ сарын 21, 22-ны өдрүүдэд шалгалт хийлээ. Шалгалтад нийт 33 этгээд хамрагдсанаас 19 этгээд харьяа байгууллагын бүртгэлгүйгээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа зөрчил илэрчээ.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулиар барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэд нь мөнгөн хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа явуулах байршлаас хамааран харьяа аймаг, дүүргийн Засаг дарга болон Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх үүрэг хүлээнэ. Мөн хуулиар анз буюу алданги тооцохыг хориглосон бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд банк, санхүүгийн байгууллагатай адил зээлийн хүүгийн хувь хэмжээг 20 хувиар тооцох зохицуулалт хийгджээ. Энэ нь хууль батлагдахаас өмнө хугацаа хэтэрсэн тохиолдолд хоногийн 0.5 хувийн алданги тооцож иргэдийг хохироож ирсэн үйлдлийг таслан зогсоосон хуулийн хамгаалалт болсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар тогтоосон бөгөөд энэхүү шийдвэр нь 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжиж эхлээд байгаа юм.

Хамтарсан шалгалтаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс баталсан зээлийн хүүгээс илүү хүү тооцон зээл олгосон, нэмэлт төлбөр, шимтгэл хураамж авсан, хаяг байршлын өөрчлөлтийг харьяа байгууллагад бүртгүүлээгүй, бүртгэлгүй салбар нээн ажиллуулсан зэрэг нийтлэг зөрчил дутагдлууд илэрсэн бөгөөд зөрчилтэй этгээдүүдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 516 этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлсэн бөгөөд эдгээрийн 348 нь хуулийн этгээдээр, 167 нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнээр бүртгэгдэж, иргэдэд чиглэсэн мөнгөн зээлийн үйлчилгээ эрхэлж байна.

Санхүүгийн зохицуулах хороо Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын хамтарсан шалгалт бүтэн жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд нийслэл, дүүрэг, аймаг орон нутагт мөнгөн зээлийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулах, мөнгөн зээлийн үйлчилгээ авч буй иргэдэд хууль сурталчлах, иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор шалгалт үргэлжилнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ХОРООДЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ БОЛЖ БАЙНА



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын 50 дахь жилийн тайлангийн хуралд оролцож байна.

Катарын Доха хотноо энэ сарын 12–15-ны өдрүүдэд болж буй хурлаар үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэхийн зэрэгцээ дижиталчлал, кибер аюулгүй байдал, зах зээлийн тогтвортой байдал зэрэг хөрөнгийн зах зээлд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх асуудлын талаар хэлэлцэж байна. Энэхүү олон улсын байгууллага нь хөрөнгийн зах зээл дээрх санхүүгийн үйл ажиллагааны хяналт, шалгалтыг сайжруулах, гишүүн орнуудынхаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан мэдээлэл солилцох тогтолцоог гүнзгийрүүлэх зорилго бүхий бүс нутгийн дөрвөн дэд

хороотой бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо Ази–Номхон далайн бүсийн хороо (APRC), Хөгжиж буй зах зээлийн хороо (GEMC)–ны гишүүн юм. Тус хороодын хурлаар зах зээлийн үр ашиг, хөрөнгө оруулагчдын хамгаалалтыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, ил тод байдлыг дэмжих мөн финтек, хиймэл оюун ухаан, тогтвортой байдлын хөгжлийн талаар хэлэлцэв.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал мөн “Хөрөнгийн зах зээлийн тогтвортой, ил тод байдлын олон улсын стандартууд”, “Крипто хөрөнгийн тогтолцоо”, “Хувийн санхүүжилтийг чиглүүлэх нь” хэлэлцүүлэгт оролцсон юм. Энэ үеэр тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зургийг хэрэгжүүлсэн туршлага, тулгарч буй бэрхшээл болон крипто болон дижитал хөрөнгийн зах зээлийн талаар баримталж буй IOSCO–ын бодлогын зөвлөмж, эдгээр зөвлөмжтэй уялдуулан хэрхэн үр дүнтэй зохицуулалтыг хэрэгжүүлэх, хувийн санхүүжилтийн чиг хандлага, эрсдэлийн талаар хэлэлцлээ.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага нь дэлхийн 130 гаруй зохицуулагч байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн хөрөнгийн зах зээлийн бодлого, стандартыг тодорхойлогч олон улсын байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хороо 2009 онд тус байгууллагын үндсэн гишүүнээр элссэн бөгөөд 2014 онд Олон талт харилцан ойлголцлын санамж бичигт нэгдсэн.

УИХ–ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЛЭЭ



УИХ–ын Эдийн засгийн байнгын хороо /ЭЗБХ/–ны хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц үйл ажиллагааны тайланг танилцуулсан бөгөөд хороо өнөөдрийн байдлаар 11 салбарын 6930 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт,

хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд энэ нь 2020 онтой харьцуулахад 20.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Санхүүгийн салбарын зах зээлийн үнэлгээ, нийт хөрөнгийн дүн өнгөрсөн онд ДНБ–ий 26.5 хувьд хүрсэн. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өмнөх оноос 11.8 хувиар буюу 1,372.5 тэрбум төгрөгөөр өсөж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд түвшинд буюу 13.0 их наяд төгрөгт хүрээд байна. Мөн 1.6 их наяд төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан нь өмнөх оноос 2 дахин өссөн.

Онцлох зарим ажлаас УИХ–аас 2024 оны 5 дугаар сард Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг баталсан. Үүний үр дүнд үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсч, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болж, дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх боломж бүрдсэн. Мөн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг үе шаттай бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж чадсан. Түүнчлэн компанийн бонд гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж, биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчныг бий болгосны үр дүнд 2024 онд биржийн болон биржийн бус зах зээлд давхардсан тоогоор 102 компани 2.7 их наяд төгрөгийг бондын зах зээлээс татан төвлөрүүлээд байна.

Даатгалын салбарын хувьд хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадавхыг дээшлүүлэх, олон улсын чиг хандлага, цаг үеийн шаардлагад нийцүүлэх зорилгоор салбарын хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах, бодлогын шинэчлэлийг бий болгохоор холбогдох хуулиудад оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулаад байна. Харин банк бус санхүүгийн байгууллагуудаас олгож буй хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, иргэд олон нийтийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын болон зээл үнэлгээний харьцааг тогтоосон. Мөн банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээр салбарын өөрийн хөрөнгөөрөө эрсдэл даах чадварыг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсныг онцолсон юм.

ЯРИЛЦЛАГА

СУДАЛГААНД СУУРИЛСАН САНХҮҮГИЙН САЛБАР



Сайн байна уу, Танд энэ өдрийн мэнд хүргэе. 2024 онд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаардаг салбаруудын өсөлт, уг өсөлтөд голлон нөлөөлсөн хүчин зүйлс юу байсан бэ?

Сайн байна уу. Танд бас энэ өдрийн мэнд хүргэе. 2024 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны нийт хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний 26.5 хувьд тэнцэхүйц хэмжээнд хүрч өмнөх оноос 1.6 пунктаар өссөн. Уг өсөлтөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 16.3 хувь, ББСБ-ын салбарын нийт хөрөнгө 8.9 хувьд хүрч голлох нөлөө үзүүлсэн.

Хорооноос бодлого зохицуулалтын арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлсэний үр дүнд дээрх үр дүнд хүрсэн. Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурийг өргөжүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкны реформ, төрийн өмчит компаниудын хувьчлал амжилттай хэрэгжиж хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгөөр өсөж 2024 онд 13.0 их наяд төгрөг буюу түүхэн дээд түвшинд хүрсэн. Үүний 5 гаруй их наяд төгрөг нь УИХ-аас баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд хийгдэж буй системийн нөлөө бүхий банкууд IPO хийснээр өссөн дүн юм. Мөн 2024 онд 1.6 их наяд төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оноос 2 дахин, 2020 оноос 24.2 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт арилжааны 57.8 хувийг буюу 913.1 тэрбум төгрөгийг компаниудын нийтэд гаргасан бонд эзэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн хүү бууруулах стратегийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэгтэй санхүүгийн салбарын өнөөгийн байдал, судалгаанд суурилсан бодлого, зохицуулалтыг бий болгох, иргэд олон нийтэд санхүүгийн салбарын тоон мэдээллийг түргэн шуурхай хүргэхтэй холбоотой хийж буй шинэчлэлүүдийн талаар ярилцлаа.

дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг үе шаттай бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, биржийн бус зах зээлийг хөгжүүлж, хөрөнгийн зах зээл хос дугуйтай болж хөрөнгийн зах зээлийн хөгжил сүүлийн 30 жилийн хамгийн дээд үзүүлэлтийг авчирсан.

Даатгалын салбарын хувьд олон тулгуурт даатгалын салбарыг хөгжүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр бодлогын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсний үр дүнд сүүлийн 5 жилийн байдлаар даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 19.4 хувиар, даатгалын хураамжийн хэмжээ 13.1 хувиар тус тус өссөн. Тус салбарын малчин айл өрхийг ядуурлаас хамгаалах хүрээнд малыг ган зудын аюулаас даатгах, зам тээврийн ослын хохирлыг бууруулах, ипотекийн зээлдэгчдийг эрсдэлээс хамгаалах зэргээр бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Мөн хөрөнгийн зах зээл дэх даатгагчдын оролцоог өсгөх, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулснаар 2024 онд даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлд оруулсан хөрөнгө оруулалт 101.7 тэрбум төгрөг болоод байна. Харин ББСБ-ын салбарын хувьд ББСБ-ын нийт хөрөнгө 2024 онд 7.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 52.5 хувиар буюу 2.5 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Үүнд зээлийн 84.5 хувийн өсөлт голлон нөлөөлжээ. Санхүүгийн зохицуулах хорооноос зүгээс банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн бөгөөд энэхүү шийдвэр нь салбарын өөрийн хөрөнгөөрөө эрсдэл даах чадварыг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой болсон.

Монгол Улсын хэмжээнд 178 Хадгаламж, зээлийн хоршоо 73,293 гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлж, хоршоодын нийт хөрөнгө 356.7 тэрбум төгрөгт хүрч, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө өмнөх оноос 5.1 хувиар өсөж 28.9 тэрбум төгрөгт хүрсэн.

Санхүүгийн салбарын тоо мэдээллийг хөрөнгө оруулагчид, зээлдэгчид, иргэд өдөр тутмын шийдвэр гаргахдаа ашигладаг. Жишээлбэл, хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгийн зах зээлийн идэвх, ББСБ-ийн зээлийн дундаж хүү, ногоон зээлийн бүтээгдэхүүн, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээлэл гэх мэт. Санхүүгийн салбарын тоо мэдээллийг цаг алдалгүй, шуурхай олон нийтэд мэдээлэх тал дээр хэрхэн ажилладаг бэ?

Санхүүгийн зохицуулах хороо иргэд олон нийтийн санхүүгийн оновчтой шийдвэр гаргалтад туслах, олон нийтийг санхүүгийн зах зээлийн үнэн зөв, ил тод, бодит мэдээллээр хангах зорилгоор зах зээлийн мэдээг 7 хоног, сар бүрээр гаргагдаас гадна зохицуулалттай салбарын тоймыг улирал бүр эрхлэн гаргаж байгаа бөгөөд эдгээр мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулдаг тул мэдээллийг оюутан залуус, санхүүгийн салбарын судлаачид эрдэм шинжилгээний ажилдаа ашиглах бүрэн боломжтой. 2025 оны 1 дүгээр сараас зохицуулалттай салбаруудын голлох тоон үзүүлэлтүүдийг POWER BI дашбоардоор мэдээлдэг болсон. Энэхүү дашбоард нь салбаруудын тоон үзүүлэлтийг нэгтгэн цаг хугацааны эрэмбээр харуулах давуу талтай бөгөөд та бүхэн сонирхсон салбарын мэдээллийг он, улирлаар авах боломжтойгоос гадна бизнесийн үйл ажиллагааныхаа төлөвлөлтөө гаргах, дүн шинжилгээ хийх, санхүүгийн оновчтой шийдвэр гаргалтад ашиглах зэрэг эерэг нөлөөг үзүүлнэ гэж харж байна.

Санхүүгийн салбар хурдацтай өсөхийн хирээр урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгохын тулд олон улсын жишигт нийцсэн, судалгаанд суурилсан бодлого, зохицуулалтын шийдвэр гаргах, хяналт хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос судалгаанд суурилсан бодлого боловсруулах, хяналт хэрэгжүүлэх чиглэлээр ямар арга хэмжээг авч хэрэгжүүлж байна вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын жишгээр судалгаа, шинжилгээнд суурилсан бодлого боловсруулах, хяналт хэрэгжүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилладаг.

Бид олон улсын шилдэг туршлагыг судлах, санхүүгийн зах зээл дээр шинээр гарч буй бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, санхүүгийн салбарын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг

хэрэгжүүлэх, системийн эрсдэлийг урьдчилан тооцсон урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулах зорилгоор 2016 оноос эхлэн судалгаа хийж, түүндээ суурилсан санал дүгнэлтийг гарган зохицуулалтдаа тусган хэрэгжүүлж байна. Эдгээр судалгааны ажлууд нь санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудыг өргөн хүрээнд хөндөн судалсны дүнд дэвшүүлсэн дүгнэлт, санал, зөвлөмжүүд нь цаг үеийн оновчтой бодлого боловсруулах, шийдвэр гаргах, арга замыг томъёолоход чухал нөлөө үзүүлж байна.

Тухайлбал, 2020–2024 онуудад хийсэн нийт 60 гаруй судалгааг 5 судалгааны товхимол болгон эмхэтгэн хэвлэмэл болон цахим хэлбэрээр гарган нийтэд хүргэсэн бөгөөд товхимолд орсон судалгааны ажлууд маань санхүүгийн зах зээлийн чиглэлээр судалгаа хийдэг хэн бүхэнд хэрэгтэй унших бүтээл болсон байх гэж харж байна. Түүнчлэн бид зарим гол чухал судалгааг захиалгаар хийлгэдэг. 2024 онд хийлгэсэн Монгол Улсын иргэдийн санхүүгийн чадамж, богино хугацааны хүндрэлийг даван туулах, бие даасан шийдвэр гаргах чадварыг буюу санхүүгийн эрүүл мэндийг хэмжих түүвэр судалгаа нь Монгол улсад анх удаагаа хийгдсэн нь онцлог байлаа. Энэхүү судалгааны үр дүнд Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийн дундаж индекс 54 гарсан нь иргэд богино хугацааны санхүүгийн дарамтад өртөх эрсдэлтэй төдийгүй тэдний орлогын болон эх үүсвэрийн найдвартай байдал харьцангуй бага түвшинд байгаа нь иргэд санхүүгийн суурь ойлголтуудын талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй хэдий ч зарим шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг илтгэж байгаа юм.

2025 он гарснаар зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох ба олон улсын туршлага, олон улсын цахим бооцоот тоглоомын хууль эрх зүйн орчин, нүүрсний зах зээлийн олон улсын болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага гэх мэт цаг үеийн шинжтэй удирдлагын шийдвэр гаргалтад нөлөөлөх судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ онд санхүүгийн зах зээл дэх өгөгдлийн аюулгүй байдал, хиймэл оюун ухааны хэрэглээ болон зохицуулалт, ногоон угаалт, түүнээс сэргийлэх олон улсын зохицуулалт, карбон трэйдinгийн чиг хандлага, санхүүгийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах олон улсын стандарт, олон улс дахь финтекийн эрх зүйн зохицуулалт зэрэг судалгааг хийхээр төлөвлөж байна.

Бид бүхний хийсэн судалгааны эмхэтгэлүүдийг Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудасны “Судалгааны товхимол” хэсгээс унших боломжтой бөгөөд санхүүгийн салбарын судалгаа, шинжилгээний чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, зөвлөх үйлчилгээ түүнчлэн ахисан түвшний судалгаа, шинжилгээ хийх оюутнууд болон судлаачидтай хамтран ажиллахад манай газар үргэлж нээлттэй байх болно.

Бидэнтэй ярилцсан танд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН УГААЛТ



“Ногоон угаалт” гэх нэр томъёог анх 1986 онд экологич Жэй Вестервэлд хэрэглэсэн. Тэрээр Фижид аялж байхдаа нэгэн амралтын газарт “байгаль орчныг хамгаалахын тулд алчуураа дахин ашиглана уу” гэсэн уриалгатай таарсан бөгөөд уг уриалга нь анх харахад экологийн хариуцлагатай үйлдэл мэт харагдах боловч, үнэн хэрэгтээ угаалгын зардлыг бууруулах зорилго бүхий маркетингийн арга хэмжээ болохыг анзаарсан. Үүнд үндэслэн байгаль орчныг хамгаалах нэрийн дор хэрэгжиж буй төөрөгдүүлсэн сурталчилгаа, уриалгын тухай шүүмжилсэн эсээ бичиж, сонинд хэвлүүлэхдээ “ногоон угаалт” гэх нэр томъёог ашигласнаар уг ойлголт олон нийтэд түгж эхэлжээ (Anna Francesca, 2025).

Ногоон угаалт (greenwashing) гэдэг нь аливаа байгууллагаас хэрэглэгч, үйлчлүүлэгчид санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ эсхүл, хэрэгжүүлж буй төслийн талаар байгальд ээлтэй мэтээр худал, баталгаагүй мэдээллийг олон нийтэд хүргэх маркетинг, сурталчилгааны хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, үүнийг байгальд ээлтэй, эсхүл байгалийн гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж буйг ашиглан ашиг олох зорилго бүхий оролдлого хэмээн ойлгож болно. Энэ нь зах зээлд шударга бус өрсөлдөөн бий болгохоос гадна хэрэглэгчийг төөрөгдүүлж, аливаа бүтээгдэхүүн үйлчилгээ, төслийн байгаль орчинд үзүүлэх бодит нөлөөллийн талаарх үр дүнгийн талаарх олон нийтийн итгэлцлийг бууруулдаг (The Future of Commerce, 2022).

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар олон компаниуд өөрсдийн нэр хаягийг өөрчлөх, шинэ төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, түүнчлэн эдгээр бүтээгдэхүүний сурталчилгаанд “байгалийн гаралтай”, “эко”, “органик”, “эрүүл”, “химийн бодисгүй” гэх мэт нэр томъёог ашиглан олон нийтийн дунд эерэг сэтгэгдэл бий болгох хандлага нэмэгдэж байна. Гэвч ихэнх тохиолдолд үүний ард бүтээгдэхүүний орц, найрлагад бодит өөрчлөлт ороогүй зөвхөн сав, баглаа боодол болон шошго, түүний мэдээллийг шинэчлэх байдлаар хэрэглэгчийн байгалийн гаралтай, эрүүл бүтээгдэхүүнд хандах эерэг хандлагыг ашиглан итгэл төрүүлэх байдлаар хэрэглэгчдийн худалдан авалтыг идэвхжүүлж, ашиг орлого нэмэгдүүлэх оролдлого байдаг.

Бид худалдан авалт хийхдээ ногоон угаалтыг хэрхэн илрүүлэх вэ?

Аливаа байгууллагын санал болгож буй байгалийн гаралтай хэмээн нэрлэсэн бүтээгдэхүүн, түүнтэй холбоотой гаргасан мэдэгдэл болон тэдгээрийн нотолгоог хайх: “байгальд ээлтэй”, “ногоон” эсвэл “байгалийн гаралтай” гэх мэт нэр томъёо нь олон нийтийг төөрөгдүүлэхүйц, өргөн хүрээтэй, амархан буруу ойлгогдох хоёрдмол утгатай тул болгоомжтой хандах хэрэгтэй. Тухайлбал, жинхэнэ “ногоон” хэмээн зарласан мэдэгдэл нь тодорхой бөгөөд баталгаажих боломжтой байх ёстой. Хэрэв бүтээгдэхүүн “байгальд ээлтэй” хэмээх шошготой бол “100% дахин боловсруулсан материалаар хийгдсэн” эсвэл “сэргээгдэх эрчим хүч ашиглан үйлдвэрлэгдсэн” гэх мэт дэлгэрэнгүй тайлбартай байх ёстой.

Бүтээгдэхүүний орц, материал, үйлдвэрлэлийн процессын талаарх мэдээлэлтэй таницах: Хэрэв бүтээгдэхүүнийг дахин боловсруулсан материал ашигласан, “Байгальд хурдан шингэдэг” гэж шошголсон бол ердийн нөхцөлд богино хугацаанд байгальд задардаг байх ёстой. Мөн тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйл явцын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх.

Ил тод байдал: Байгаль орчныг хамгаалах чиглэлд эсхүл, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь өөрсдийн байгаль орчны хүчин чармайлтын талаар тайлан, мэдээллийг тодорхой хугацааны давтамжтай олон нийтэд хүргэдэг. Иймд үйл ажиллагааныхаа талаар тогтмол ил тод мэдээлэлдэг байгууллагын бүтээгдэхүүнийг сонгох хэрэгтэй.

Үнэн боловч ач холбогдол багатай, чухал бус мэдээллийг ашиглаж буй эсэхийг нягтлах: Зарим байгууллагууд бүтээгдэхүүнээ “CFC агуулаагүй” гэж мэдэгддэг ч энэхүү мэдээлэл нь бодитоор үнэн хэдий ч ач холбогдол багатай, учир нь CFC (хлорфторт нүүрстөрөгч) нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор аль хэдийн хориглогдсон бодис юм. Ийм төрлийн мэдэгдэл нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүн байгальд ээлтэй гэсэн өөрчлөлт хийгдсэн мэт ташаа ойлголт төрүүлэх эрсдэлтэй. Мөн зарим тохиолдолд бүтээгдэхүүний зөвхөн нэг зэрэг чанарыг онцлон сурталчилж, бусад сөрөг нөлөөлөл, эрсдэлийг зориуд дурдахгүй орхих магадлалтай тул ийм төрлийн маркетингийн арга техникт хянуур хандах шаардлагатай.

Ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулах: Бүтээгдэхүүн худалдан авахдаа ижил төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн процесс, ашиглагдаж буй түүхий эд, хүлэмжийн хийн ялгаруулалт, байгальд үзүүлэх нийт нөлөөллийг харьцуулан судлах хэрэгтэй.

Ногоон угаалтын сөрөг үр дагаврууд

Хог хаягдлыг нэмэгдүүлэх: Ногоон угаалтын үр дагаварт дахин боловсруулах боломжгүй хог хаягдал нэмэгдэж, энэ нь хог хаягдлын менежментийн үр нөлөөг бууруулахын зэрэгцээ байгаль орчны доройтлыг улам хурцатгахад нөлөөлдөг. Үүний үр дүнд хөрс, ус, агаарын бохирдол нэмэгдэж, байгаль орчны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө.

Байгаль орчны доройтол нэмэгдэх: Ногоон угаалт хийж буй компаниуд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйл ажиллагаагаа зогсоохын оронд төөрөгдүүлсэн маркетинг ашиглан олны анхаарлыг өөр тийш хандуулах замаар бодит хохирлыг далдлах хандлагатай байдаг. Үүний үр дүнд бохирдол, нөөцийн хэт хэрэглээ, хог хаягдлын зохисгүй менежмент зэрэг асуудлууд шийдэгдэхгүй үлдэж, байгаль орчны доройтол үргэлжилсээр байдаг.

Олон нийтийн итгэлцлийг бууруулах: Хэрэглэгчид ногоон угаалтын золиос болох тохиолдол нэмэгдэхийн хэрээр байгаль орчны талаарх аливаа мэдэгдэлд, тэр дундаа жинхэнэ тогтвортой практик хэрэгжүүлж буй байгууллагын мэдээлэлд хүртэл эргэлзэх хандлага бий болдог. Энэ нь олон нийтийн дэмжлэгийг бууруулж, улмаар байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Зохицуулалт ба бодлогын үр дагавар: Ногоон угаалт нь тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Хэрэв байгаль орчны талаарх худал, төөрөгдүүлсэн мэдээлэл зах зээлд өргөн тархвал зохицуулагч байгууллагууд стандартыг мөрдүүлэхэд хүндрэлтэй болж, бодлого боловсруулагчдын зүгээс бодит үр дүнд чиглэсэн, үр нөлөөтэй хөтөлбөр боловсруулах боломж хязгаарлагдана. Энэ нь байгаль орчны шаардлагатай бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг удаашруулах эрсдэлтэй юм.

Эх сурвалж: *The Future of Commerce, 2024. “What is Greenwashing?”, Available at: <https://www.the-future-of-commerce.com/2022/10/25/greenwashing-definition-stats/>*

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТУЗ–ИЙН 2025 ОНД АНХААРАХ 5 СОРИЛТ

Судалгааны үргэлжлэл...

Сорилт 5: Мэргэшил эсвэл ерөнхий манлайллын туршлага

ТУЗ–ийн оролцоог шаардсан, өргөн хүрээнд мэргэшлийн асуудалтай тулгарч байгаа өнөөгийн нөхцөлд үр дүнтэй засаглалыг хэрэгжүүлэхийн тулд нарийн мэргэжлийн мэдлэг ур, чадвар шаардагдана.

ТУЗ нь мэргэшил (тухайлбал, технологи, кибер аюулгүй байдал)–ийн шаардлага болон бизнесийн үйл ажиллагаа, стратегийн асуудлуудыг өргөн хүрээний туршлагатай манлайлагчдын хэрэгцээг хэрхэн тэнцвэржүүлэх вэ?

ТУЗ–ийн бүрэлдэхүүн нь уламжлалт байдлаар гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага дээр төвлөрдөг. Тухайн салбарын мэдлэг хурдан хуучирдаг бол олон жилийн турш хуримтлагдсан стратегийн манлайллын ур чадвар илүү удаан хадгалагдаж байдаг. Урьдчилан тааварлах боломжгүй өнөө үед бизнесийн орчинд манлайллын туршлага зайлшгүй хэрэгтэй хэвээр. Үүнд:

- Уян хатан байдал – өөрчлөлтөд дасан зохицох чадвар;
- Ашиг сонирхлыг тэнцвэржүүлэгч – оролцогч талуудын хүлээлтийг удирдах чадвар;
- Стратегийг эрс өөрчлөх, хямралд хариу үйлдэл үзүүлэх – шаардлагатай үед оновчтой, зоригтой хурдан шийдвэр гаргах чадвар.

Спенсер Стюарт судалгааны байгууллагын мэдээллээр, S&P 500 индексийн компаниудын ТУЗ–ийн шинэ гишүүдийн 30 хувь нь “үүрэг гүйцэтгэж байгаа эсвэл тэтгэвэртээ гарсан гүйцэтгэх захирлууд” байдаг бөгөөд энэхүү үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа хэдий ч, арван жилийн өмнөхтэй харьцуулбал 5 хувиар буурсан байна.


Энэхүү уламжлалт хандлагын эсрэг байр суурь нь стратегийн болон өргөн хүрээний манлайллын чадвар нь өмнөх үеэ бодвол бүх салбарт түгээмэл хэрэглэгдэхээ больсон явдал. Учир нь өнөө үед бизнесийн үнэ цэн болон эрсдэл нь хурдацтай хөгжиж буй технологи, нийлүүлэлтийн сүлжээ, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлах болсонтой холбоотойгоор нарийн мэргэжлийн мэдлэг, ур чадвартай мэргэшсэн хүмүүсийг ажилд авах чиглэл давамгайлж байгаа нь судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна.

NACD–ийн 2025 оны тэргүүлэх чиг хандлагын судалгаанд оролцогчдын ихэнх нь (67%) ТУЗ–ийн гишүүнийг сонгохдоо нарийн мэргэжилтэй мэргэшсэн хүнийг илүүд үзэх магадлал өндөр гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 25 хувь нь технологийн мэргэжлийн ур чадварт гол анхаарал хандуулсан бол, 42 хувь нь хамгийн их эрэлт хэрэгцээтэй байгаа “тусгай” мэргэжил гэдгийг онцолсон байна. Гэсэн хэдий ч нарийн мэргэжилтэй, мэргэшсэн гүйцэтгэх захирлууд ихэнх тохиолдолд ашиг сонирхлын зөрчлөөс

зайлсхийхийн тулд тэтгэвэрт гарах шаардлагатай болдог нь анхаарал татаж байна.

ТУЗ–д хамгийн их эрэлттэй байгаа шинж чанар:



Эх сурвалж: 2025 оны NACD чиг хандлага ба тэргүүлэх чиглэлийн судалгаа, n=248

Анхаарах зүйлс

Тэнцвэртэй ТУЗ нь ажиллах хугацаандаа ур чадварын олон талт байдлыг хангахыг зорьдог бөгөөд ингэснээр интитуцийн түвшний мэдлэг, манлайлал болон тулгарч буй асуудлын талаарх ойлголтыг зөв хослуулах боломжийг бүрдүүлдэг.

ТУЗ нь ур чадварын хослолд тогтмол хяналт тавих шаардлагатай бөгөөд ур чадварын уян хатан бодлого, стратегитай байх ёстой. Ингэснээр ТУЗ–ийн бүрэлдэхүүний үр дүнт байдлыг баталгаажуулдаг;

Зөвхөн нарийн мэргэжлийн ур чадвараар нь элсүүлэхээс зайлсхийх. Сонгон шалгаруулах явцад ТУЗ нь бусад салбарт ажиллах чадвартай, найдвартай манлайллын туршлагатай мэргэжилтнийг хайх хэрэгтэй бөгөөд туршлага нь хувь нэмэр оруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг;

ТУЗ бүрэлдэхүүнээ нэг төрлийн мэргэжилтнүүдээс бүрдүүлэхээс илүүтэйгээр шинэ технологи, салбарын асуудал гэх мэт амин чухал асуудлаар ур чадвараа дээшлүүлэхийн төлөө ажиллах ёстой. Иймд ТУЗ бүх гишүүдийн ур чадварыг дээшлүүлэх хамтын сургалтын төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй. Бие даасан удирдагчдын үүрэг нь идэвхтэй, тасралтгүй суралцах явдал юм.

Дүгнэхэд, үйл явцыг урьдчилан таамаглахад хэцүү боловч одоогийн чиг хандлагаас харахад, ТУЗ–үүд таамаглах боломжгүй гэнэтийн нөхцөл байдалд бэлтгэлтэй байх нь чухал бөгөөд компанийнхаа өрсөлдөх чадвартай хүчин зүйлийн тэнцвэрийг зөв олох чадварыг бэхжүүлэхэд төвлөрч чадвал 2025 онд тулгарах сорилтуудыг амжилттай даван туулах бат бөх байр суурьтай болох боломжтой NACD–ийн 2024 оны “ТУЗ–ийн үйл ажиллагаа ба хяналт” судалгаагаар ТУЗ–ийн ердөө 13 хувь нь өөрсдийн тайланг “маш үр дүнтэй” гэж үнэлжээ. Иймд ТУЗ–ийн гишүүд тайлангийн шинэ стандартыг тогтоохын тулд гүйцэтгэх удирдлагын баг болон ТУЗ–ийн нарийн бичгийн даргатай хамтран ажиллах шаардлагатай.

Үргэлжлэл бий..

Эх сурвалж: www.nacdonline.org

ФИНТЕК БА РЕГТЕК

ШИЛДЭГ 10: P2P ЗЭЭЛИЙН ПЛАТФОРМУУД

9. Linked Finance (Ирланд)



Гүйцэтгэх захирал: Niall O'Grady

Төв байр: Дублин, Ирланд

2013 онд байгуулагдсан Linked Finance нь Ирландын хамгийн том P2P зээлийн платформ болон өсөж хөгжсөн бөгөөд Ирландын жижиг, дунд бизнесүүдийг орон нутгийн бизнесүүдэд хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүмүүстэй холбодог. Энэхүү платформ нь жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, зочлох үйлчилгээ зэрэг хэд хэдэн салбарт 10,000–500,000 еврогийн хооронд зээл олгоход дэмжлэг үзүүлдэг. Зээлийн өргөдлийн зөвхөн 25 орчим хувийг батлах хатуу шалгуур бүхий зээлийн үнэлгээний аргачлал ашигладаг бөгөөд хөрөнгө оруулагчдад жилд 6–11 хувийн хүлээгдэж буй өгөөжийг санал болгодог. Linked Finance нь 3,500 гаруй Ирландын бизнест нийт 250 сая еврогийн зээл олгожээ.

8. Folk2Folk (Их Британи)



Гүйцэтгэх захирал: Roy Warren

Төв байр: Лонсестон, Корнуолл, Их Британи

2013 онд байгуулагдсан Folk2Folk нь Их Британийн орон нутгийн бизнесүүдэд зориулсан, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан зээлээр дагнасан P2P зээлийн платформ юм. Бүх зээл нь Их Британийн үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан байдаг (ихэвчлэн зээл/үнэлгээний харьцаа 60%), ингэснээр хөрөнгө оруулагчдад бодит хөрөнгөн дээр суурилсан баталгаа олгодог. Энэхүү платформ нь тогтмол 8.75% жилийн өгөөж, сар бүрийн хүүгийн төлөлт бүхий энгийн хөрөнгө оруулалтын загварыг санал болгодог бөгөөд өнөөг хүртэл хөдөө аж ахуй, зочлох үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн салбарын бизнесүүдэд ихэвчлэн чиглэсэн нийт 760 сая фунтийн зээлийг Их Британийн хөдөө орон нутгийн бүс нутагт зуучлаад байна.

7. Mintos (Их Британи)



Гүйцэтгэх захирал: Martins Sulte

Төв байр: Рига, Латви

Холбогдох мэдээлэл: MiFID-ийн зохицуулалттай, Европын

тэргүүлэгч хөрөнгө оруулалтын платформ бөгөөд 2023 оны эцсийн байдлаар 610 сая еврогийн гаруй хөрөнгийг удирдаж байна

2014 онд байгуулагдсан Mintos нь Латвид төвтэй бөгөөд Европын хөрөнгө оруулалтын платформ юм. Анх гуравдагч этгээдийн зээл олгогч компаниудын зээлийг олон зах зээл дээр хөрөнгө оруулагчидтай холбож эхэлсэн бөгөөд 2021 онд MiFID-ийн лицензийг авч, хуваарилагдсан бонд болон Хөрөнгийн биржээр арилжаалагддаг сан (ETF)-ууд руу стратегийн өргөжилт хийх боломжтой болсон. Энэхүү платформ нь хөрөнгө оруулагчдыг хамгаалах зохицуулалтын чадамжтай бөгөөд хөрөнгө оруулалтын төрөлжилтийг дэмждэг. 500,000 гаруй хэрэглэгчийг бүртгэж нийт 611 сая еврогийн хөрөнгийг удирдаж байна.

6. October (Франц)



Гүйцэтгэх захирал: Olivier Goy

Төв байр: Парис, Франц

Анх 2014 онд (эхэндээ Lendix нэртэйгээр) байгуулагдсан October нь Франц, Испани, Итали, Нидерланд болон Герман улсуудыг хамарсан Европын тэргүүлэгч жижиг, дунд бизнесийн зээлийн платформ болон хөгжсөн. Энэхүү платформ нь хувь хүн болон байгууллагын хөрөнгө оруулагчдыг жижиг, дунд бизнесүүдэд шууд зээл олгох боломжийг олгодог бөгөөд зээлийн хэмжээ нь 30,000–аас 5 сая еврогийн хооронд хэлбэлздэг. October нь уламжлалт бизнесийн шинжилгээнээс гадна өөрийн боловсруулсан кредит онооны алгоритмыг ашиглан зээлдэгчдийн үнэлгээг хийдэг бөгөөд 3,300 гаруй төслүүдэд нийт 840 сая еврогийн зээлийг зуучлаад байна.

5. Assetz Capital (Их Британи)



Гүйцэтгэх захирал: Stuart Law

Төв байр: Манчестер, Их Британи

2013 онд байгуулагдсан Assetz Capital нь жижиг дунд бизнес, үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэгчид болон сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд зориулсан үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан зээл олгодог Их Британийн хамгийн том P2P

зээлийн платформуудын нэг болон хөгжжээ. Платформ дээрх бүх зээл нь үл хөдлөх хөрөнгө зэрэг бодит хөрөнгөөр баталгаажсан байдаг бөгөөд эрсдэлийн түвшнээс хамааран 4.1%–12% хүртэлх зорилтот өгөөжтэй, төрөл бүрийн хөрөнгө оруулалт санал болгодог. Asset Capital нь нийт 1.5 тэрбум фунтийн зээлийг Их Британийн бизнесүүдэд зуучилсан бөгөөд зээлийн баталгааны чанар болон нийгэм, эдийн засгийн үр нөлөөг онцлон анхаардаг. Үүний үр дүнд 8,000 гаруй ажлын байр, 6,000 гаруй орон сууц шинээр бий болоход дэмжлэг үзүүлжээ.

4. Kiva (АНУ)



Гүйцэтгэх захирал: Vishal Ghotge

Төв байр: Сан Франциско, Калифорни, АНУ

2005 онд байгуулагдсан Kiva нь хөгжиж буй орнуудын бизнес эрхлэгчдийг дэмжих зорилготой, ашгийн бус олон улсын байгууллага юм. Энэхүү платформ нь хувь хүмүүсийг дэлхийн өнцөг булан бүр дэх жижиг бизнес эрхлэгч, фермер, оюутнуудтай холбож, ердөө 25 ам.доллаароос эхлэн зээл олгох боломжийг олгодог. 96.3% зээлийн эргэн төлөлтийн түвшинтэй нь энэхүү загварын тогтвортой байдал, найдвартай байдлыг харуулдаг. Kiva нь 83 улсад нийт 2.1 тэрбум ам.долларын зээлийг зуучилж, 5 сая зээлдэгчид хүрч ажилласан.

3. PeerBerry (Европ, Хорват)



Гүйцэтгэх захирал: Arunas Lekavicius

Төв байр: Загреб, Хорват

2017 онд байгуулагдсан PeerBerry нь Европ даяар богино хугацаат хэрэглээний зээл, бизнесийн санхүүжилт, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын боломжуудыг санал болгодог P2P хөрөнгө оруулалтын платформ юм. Энэхүү платформ нь ойролцоогоор 100,000 хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж, жилд дунджаар 10–12% өгөөж санал болгодог. PeerBerry нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо сайтай бөгөөд түнш байгууллагуудын баталгаа болон buyback зэрэг хамгаалалтын механизмыг ашигладаг. Зээлийн эх үүсвэрийн ихэнх нь Aven-

tus Group-ийн охин компаниудаас гаралтай бөгөөд PeerBerry нь Украины дайнд өртсөн зээлийн хөрөнгө оруулагчдад нөхөн төлбөрийг амжилттай олгосон зэрэг нь хүнд нөхцөлд ч найдвартай байж чаддаг платформ болохыг харуулж чадсан.

2. Bondora (Эстони)



Гүйцэтгэх захирал: Pdrtel Tomberg

Төв байр: Таллин, Эстони

2008 онд байгуулагдсан Bondora нь 100 гаруй орны хөрөнгө оруулагчдыг Финланд, Эстони, Испанийн зээлдэгчидтэй холбодог. Платформын гол бүтээгдэхүүн болох Go & Grow нь хөрөнгө оруулалтыг хялбаршуулсан бөгөөд жилд 6.75%-ийн зорилтот өгөөж болон шууд хөрвөх боломжоор (instant liquidity) онцлог. Bondora нь 230,000 гаруй зээлдэгчид нийт 850 сая еврогийн зээлийг зуучлаад байгаа бөгөөд зээлийн түүхэн үзүүлэлт, өгөгдлийг нээлттэй, ил тод байдлаар нийтэлдэг нь хөрөнгө оруулагчдад өндөр түвшний мэдээллийн хүртээмжийг бий болгодог.

1. Prosper Marketplace (АНУ)



Гүйцэтгэх захирал: David Kimbal

Төв байр: Сан Франциско, Калифорни, АНУ

2005 онд байгуулагдсан бөгөөд Америкийн анхны P2P зээлийн платформ болсон Prosper нь институцийн хөрөнгө оруулалттай хослуулан жижиглэнгийн (хувь хүн) хөрөнгө оруулагчдад анхаарсан P2P зарчмаа хадгалсаар иржээ. Тэд өрийг нэгтгэх, орон сууцны засвар, томоохон зардал зэрэгт зориулсан 2,000–50,000 ам.долларын хувь хүний зээл, түүнчлэн орон сууцны өмчлөлийн зээл болон кредит картын бүтээгдэхүүнүүдийг санал болгодог. 2 сая гаруй зээлдэгчид нийт 28 тэрбум ам.доллаароос давсан зээлийг зуучилсан Prosper нь хөрөнгө оруулагчдад дунджаар 5.3%-ийн өгөөж санал болгодог. Бараг 20 жилийн турш үйл ажиллагаагаа тогтвортой явуулж ирсэн нь тэдний бизнесийн загвар эдийн засгийн олон үе шатыг даван туулж чадсан найдвартай байдлыг илтгэнэ.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/articles/top-10-peer-to-peer-lending-platforms>

СУДЛААЧИЙН ИНДЭР

НОГООН ЗЭЭЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Гал

ХУРААНГУЙ

Монгол Улсад ногоон зээл ба түүний баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах боломжийг судлах нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чиглэсэн томоохон алхам болох юм. Энэхүү судалгаа нь ногоон зээлийн баталгаажуулалтын олон улсын туршлага, Монгол Улсын нөхцөл байдлыг судалж, санхүүгийн салбарын хөгжлийн чиг хандлага болон тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн санал, зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн.


Ногоон зээлийн баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох нь байгаль орчныг хамгаалах, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй болохыг энэхүү судалгаагаар дүгнэсэн.

Манай улсын санхүүгийн байгууллагууд ногоон зээлийн баталгаажуулалтын хувьд зөвхөн дотоод баталгаажуулалтыг ашиглаж байгаа ба цаашид хөндлөнгийн баталгаажуулалтын механизмыг хөгжүүлэх шаардлагатай байна.

ОРШИЛ

Тогтвортой хөгжил нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилсан дэлхийн нийтийн урт хугацааны бодлого бөгөөд үүний нэг чухал бүрдэл нь тогтвортой санхүүжилтийн тухай ойлголт юм.

Зураг. Тогтвортой санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгүүд



Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Сүүлийн үед байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа буюу ногоон бизнес эрчимтэй хөгжиж байгаа нь ажиглагдаж байна. Учир нь бизнесийн байгууллага болон хувь хүмүүс нийгмийн хариуцлагынхаа хүрээнд байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжүүлэх болон хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж байна.

Ногоон зээл нь зээлдэгчдэд зээлийн хөрөнгийг зөвхөн байгаль орчны зорилгод ихээхэн хувь нэмэр оруулах төслүүдийг санхүүжүүлэхэд ашиглах боломжийг олгодог санхүүжилтийн нэг хэлбэр юм (Дэлхийн банк, 2021). Ногоон зээлийн бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих, цаашид бататган бэхжүүлэх зорилгоор Зээлийн зах зээлийн нийгэмлэг (LMA), Ази Номхон далайн зээлийн зах зээлийн нийгэмлэг (APLMA), Зээлийн хамтын ажиллагаа, арилжааны нийгэмлэг (LSTA) зэрэг байгууллагуудын санаачилгаар Ногоон зээлийн зарчим (GLP) боловсруулсан. Энэхүү зарчим нь салбарын мэргэжилтнүүдэд нэгдсэн ойлголт, нэгдмэл арга барилыг дэмжихэд чиглэгдсэн юм.

Ногоон зээлийн зарчим (GLP) нь ногоон зээлүүдийг ашиглах, удирдах хүрээг тодорхойлж, санхүүжилтийг тодорхой байгаль орчны ашиг тустай төслүүдэд зарцуулж буйг баталгаажуулдаг. Энэхүү зарчим нь дараах 4 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Орлогын ашиглалт: Зээлсэн хөрөнгийг зөвхөн байгаль орчинд ээлтэй төслүүдэд зарцуулахад чиглүүлэхийг хэлнэ. Эдгээр нь ихэвчлэн сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, барилга байгууламж, үйлдвэрлэлийн байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, усны тогтвортой менежментийн систем, бохирдлыг бууруулах технологи, биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх төслүүдийг багтаадаг. Зээлдэгч нь урьдчилан тодорхойлсон ногоон шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хөрөнгийг хэрхэн хуваарилж байгааг ил тод баримтжуулж, тайлагнах ёстой. Санхүүгийн эх үүсвэр нь байгаль орчны тогтвортой байдлын зорилтуудыг хэрэгжүүлэхэд шууд хувь нэмэр оруулах замаар ногоон зээлийн найдвартай байдал, үр нөлөөг баталгаажуулдаг.

Үнэлгээ ба сонгон шалгаруулалтын үйл явц: Зээлдэгч нь санхүүжүүлэх төслийн байгаль орчны зорилтыг нарийн тодорхойлж, төсөл бүр ногоон санхүүжилтийн шалгуурт хэрхэн нийцэж байгааг нотолж өгдөг. Зээлдүүлэгч шийдвэр гаргах үйл явцад дотоод болон гаднын мэргэжилтнүүдийг оролцуулан байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нарийн үнэлэхийн тулд төслийн шалгуурыг тогтоодог. Зээлдэгч зээлийн найдвартай байдлыг бэхжүүлэхийн тулд төслүүдийг ногоон стандартыг чанд мөрдөж, байгаль орчинд хэмжигдэхүйц үр өгөөжийг өгөхийн тулд бие даасан үнэлгээнд хамрагдах боломжтой.

Орлогын менежмент: Ногоон зээлийн хувьд орлогын менежмент нь зөвхөн байгаль орчинд тодорхой үр өгөөж өгөх төслүүдэд зээлсэн хөрөнгийг авч, хуваарилах явдал юм. Зээлдэгч нь ногоон зээлийн санг бусад санхүүгийн эх үүсвэрээс салгах зорилгоор тусгай данс эсвэл хяналтын механизмыг бий болгож, сангийн менежментийн ил тод, хариуцлагатай байдлыг хангаж шаардлага хангасан төслүүдэд хөрөнгө оруулах юм. Санхүүгийн хуваарилалт, зарцуулалтыг хянахын тулд тогтмол тайлагнах нь нэн чухал бөгөөд ногоон зээлийн найдвартай байдал, нөлөөллийг бэхжүүлэх зорилгоор дотоод хяналт, засаглалын бүтцийг бий болгодог.

Тайлагналт: Ногоон зээлийг тайлагнах нь зээлсэн хөрөнгийг зөвхөн байгаль орчинд ээлтэй төслүүдэд хэрхэн хуваарилж байгааг ил тод баримтжуулах явдал юм. Зээлдэгч нар орлогын ашиглалтын талаар дэлгэрэнгүй тайланг тогтмол гаргаж, ямар төсөл санхүүжилт авсан, эдгээр санаачилга нь байгаль орчны тогтвортой байдлын зорилгод хэрхэн хувь нэмэр оруулж байгааг тодорхой тусгаж өгөх шаардлагатай. Зээлдүүлэгчид, хөрөнгө оруулагчид, зохицуулагчид, олон нийт зэрэг оролцогч талууд ногоон зээлийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг үнэлэхдээ эдгээр тайланд тулгуурладаг. Төсөл сонгон шалгаруулах шалгуурыг боловсронгуй болгох, нөлөөллийг хэмжих арга зүйг сайжруулах, ногоон санхүүжилтийн санаачилгуудаар дамжуулан тогтвортой хөгжлийг урагшлуулахын тулд тайлангийн санал хүсэлтийг мөн ашигладаг.

Хөндлөнгийн хяналт: Зээлдүүлэгч зээл нь ногоон зээлийн зарчимд нийцэж байгаа эсэхийг үнэлэхийн тулд хөндлөнгийн хяналтад хамрагдахыг зөвлөдөг. Энэхүү хөндлөнгийн хяналтыг ногоон санхүүгийн чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүд, баталгаажуулалтын эсвэл үнэлгээний агентлагууд хийж болно.

Эдгээр зарчмуудыг баримталснаар ногоон зээл нь зээлсэн хөрөнгийг тогтвортой төслүүдийг дэмжих, байгаль орчны үр өгөөжийг нэмэгдүүлж, ногоон санхүүжилтийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дундажтай харьцуулахад хурдтай явагдаж байгаа бөгөөд энэ нь бэлчээрийн доройтол, жилд дунджаар унах хур тунадасны хэмжээ багасах, биологийн төрөл зүйлийн цөөрөлт, цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж нэмэгдэх зэрэг үзэгдлүүдээс тод харагдаж байна. Иймээс ногоон санхүүжилтийн тусламжтайгаар дээрх асуудлуудыг шийдвэрлэх боломжтой бөгөөд энэхүү судалгааны ажлаар ногоон зээлийн баталгаажуулалтын орчныг бусад улсын туршлагатай харьцуулан судлах зорилготой юм.

Энэхүү судалгааны ажил нийт 5 бүлэгтэй. Дараагийн бүлэгт ногоон зээлийн баталгаажуулалтын талаар танилцуулна. Судалгааны гурав, дөрөв дүгээр бүлэгт харгалзан Олон улсын болон Монгол Улсын ногоон зээлийн баталгаажуулалтын өнөөгийн байдал, түүний зохицуулалтын талаар тусгасан. Харин эцсийн тавдугаар бүлэгт дүгнэлт, саналыг оруулав.

НОГООН ЗЭЭЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Ногоон зээлийн баталгаажуулалт нь зээл олгогч байгууллагууд болон зээлдэгчдийн ногоон зээлээр санхүүжүүлж буй төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, шалгах, батлах үйл явц юм. Энэхүү баталгаажуулалт нь төслүүдийн ногоон зээлийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг.

Ногоон зээлийн баталгаажуулалтын давуу тал

Итгэлцэл ба найдвартай байдал: Ногоон зээлийн найдвартай байдлыг дээшлүүлж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад санхүүгийн эх үүсвэрийг байгаль орчинд хувь нэмэр оруулж буй эсэхийг баталгаажуулна.

Эрсдэл бууруулах: Ногоон угаалт буюу санхүүгийн эх үүсвэрийг ногоон төслүүдэд ашиглаж буйгаар худал тайлагнах эрсдэлийг тодорхойлж, багасгахад тусалдаг.

Зах зээлийн хөгжил: Баталгаажуулсан ногоон зээлүүд нь ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, жишиг тогтоож, сайн туршлагаудыг урамшуулдаг.

Хүрээ болон стандартууд

Ногоон зээлийн баталгаажуулалтын үйл явцыг хангах хэд хэдэн хүрээ болон стандартууд байдаг тэдгээрийг нэрлэвэл:

Хөндлөнгийн хяналтын удирдамж (ERG) – Loan Market Association (LMA), Asia Pacific Loan Market Association (APLMA), болон Loan Syndications and Trading Association (LSTA) зэрэг байгууллагуудаас боловсруулсан эдгээр зарчмууд нь ногоон зээлийн хөндлөнгийн хяналтын удирдамж.


Ногоон зээлийн зарчмууд (GLP) – Climate Bonds Initiative байгууллагаас эрхлэн гаргасан энэ стандарт нь ногоон зээлийн зарчмын удирдамж юм.

Ногоон бондын зарчмууд (GBP) – Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)-ын Ногоон бондын зарчмууд нь голчлон бондод зориулагдсан боловч мөн ногоон зээлд хэрэглэх боломжтой удирдамж юм.

Ногоон зээлийн баталгаажуулалтын төрлүүд

Олон улсын холбоод болон мэргэжилтнүүдийн боловсруулсан ногоон зээлийн стандарт, хүрээнд тулгуурлан ногоон зээлийн баталгаажуулалтын дараах төрлүүд байдаг.

Зураг . Ногоон зээлийн баталгаажуулалтын төрөл



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Хоёрдогч этгээдийн санал (Second-Party Opinions) – Хөндлөнгийн байгууллага нь ногоон зээлийн хүлээн зөвшөөрөгдсөн стандарт эсвэл зарчимтай нийцлийг үнэлдэг. Бүрэн аудит хийх шаардлагагүйгээр хөндлөнгийн үнэлгээ хийж, зардал болон найдвартай байдлыг хангадаг. Гэрчилгээжүүлэх үйл явц шаардагдахгүйгээр ногоон байдлын үнэлгээ болон баталгаажуулалтыг хайж буй компаниудад зориулсан баталгаажуулалт.

Гуравдагч этгээдийн баталгаажуулалт (Third-Party Verification) – Гаднын аудит ногоон зээл нь тодорхой стандартууд болон шалгуурын дагуу нийцэж буйг дэлгэрэнгүй хянаж үздэг. Энэхүү нарийвчилсан үнэлгээний явцын ачаар найдвартай байдлыг бүрэн хангадаг. Мөн ногоон зээлд баталгаа болон ил тод байдлыг хүсэж буй компаниудад зориулсан баталгаажуулалт.

Гэрчилгээжүүлэлт (Certification) – Хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээжүүлэх байгууллага нь ногоон зээлийг тодорхой хүрээ эсвэл стандартаар баталгаажуулна. Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх өндөр түвшний баталгаа болон найдвартай байдлыг хангадаг.

Дотоодын баталгаажуулалт (Self verification) – Зээлдэгч нь ногоон зээлийнхээ холбогдох зарчимд нийцэж буйг өөрийн үнэлгээгээр шалгадаг. Зардал багатай, уян хатан, тодорхой хэрэгцээ ба нөөцөд тохируулан өөрчлөх боломжтой. Ногоон санхүүжилтийн стратегиа хэрэгжүүлэх эхний шатандаа байгаа жижиг компаниуд буюу байгууллагууд ихэвчлэн ашигладаг.

Хүснэгт. Ногоон зээлийн баталгаажуулалтын төрөл

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТӨРЛҮҮД	ТОДОРХОЙЛОЛТ	ДАВУУ ТАЛ	ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД	ХЭРЭГЛЭЭНИЙ ТОХИОЛДОЛ
Хоёрдогч этгээдийн санал (Second-Party Opinions)	Ногоон зарчимд нийцүүлсэн бие даасан үнэлгээ	Тэнцвэртэй зардал ба найдвартай байдал	Sustainalytics, Vigeo Eiris, ISS ESG	Найдвартай байдлыг эрэлхийлж буй дунд хэмжээний компаниуд
Гуравдагч этгээдийн баталгаажуулалт (Third-Party Verification)	Хөндлөнгийн аудиторын нарийвчилсан хяналт	Баталгаа	PwC, KPMG, EY	Нарийвчилсан баталгаа шаарддаг их хэмжээний зээл
Гэрчилгээжүүлэлт (Certification)	Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын гэрчилгээ	Баталгаатай, бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэгдэх боломжтой	Green Loan Principles	Томоохон корпорацууд, санхүүгийн байгууллагууд
Дотоодын баталгаажуулалт (Self Verification)	Зээлдэгчийн дотоод үнэлгээ	Зардал багатай, уян хатан	Дотоод багууд	Жижиг компаниуд, эхний шатны ногоон санхүүжилт

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

НОГООН ЗЭЭЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

БНХАУ–ЫН ТУРШЛАГА

Парисын хэлэлцээрийн хүрээнд 2020 оны 9 дүгээр сарын 22–ны өдөр БНХАУ–ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ–ын Уур амьсгалын асуудлаар бага хурлын үеэр Хятад Улс 2060 оноос өмнө нүүрстөрөгчийн хэмжээг багасгаж, зорилтот хэмжээнд хүрнэ гэж зарласан. "Standard Chartered"–ийн судалгааны багийн нийтэлсэн тайланд дурдсанаар, нүүрстөрөгчийг саармагжуулах зорилгодоо хүрэхийн тулд Хятад Улс 2060 оноос өмнө нүүрстөрөгчийг саармагжуулах үйл явцад 127–192 их наяд юань хүртэлх хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бөгөөд ингэснээр жилд дундажаар 3.2–4.8 их наяд юаньтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болно..

Хятад Улс ногоон санхүүгийн хэрэгслийн иж бүрэн бөгөөд олон шатлалтай тогтолцоог бий болгосон ба үүнд ногоон зээл, ногоон бонд, ногоон даатгал, сан, итгэлцлийг хөгжүүлэх зэрэг харьцангуй боловсронгуй хэрэгслүүд, мөн ногоон лизинг зэрэг шинээр гарч ирж буй хувилбарууд багтаж байна. Цаашилбал, Хятад Улс нүүрстөрөгч багатай шилжилт, далай тэнгисийг хамгаалах, биологийн олон янз байдлыг хамгаалах, хөдөө тосгоны сэргээн босголтыг ногоон санхүүгийн тогтолцоонд нэгтгэж шилжилтийн санхүүжилт зэрэг холбогдох деривативуудыг бий болгосон. Үүнд:

- Ногоон зээл
- Ногоон түрээс
- Ногоон бонд
- Ногоон даатгал
- Ногоон сангууд
- Ногоон итгэлцэл
- Нүүрстөрөгчийн санхүүжилт
- Шилжилтийн үеийн санхүүжилт

Ногоон зээлийн системийн бүтээн байгуулалт

Бусад ногоон санхүүгийн салбартай харьцуулахад Хятад Улсын ногоон зээл эрт эхэлсэн. 2012 оноос хойш Хятадын банкны болон даатгалын зохицуулах хорооноос "Ногоон зээлийн удирдамж гаргах тухай Хятадын банкны зохицуулах хорооны мэдэгдэл", "Хятадын банкны зохицуулах хорооны Ногоон зээлийн ажлын талаарх ерөнхий газрын дүгнэлт", "Ногоон зээлийн хэрэгжилтийн гол үнэлгээний үзүүлэлтүүд" зэрэг бодлогын баримт бичгийг банк санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтцийг идэвхтэй тохируулах, ногоон санхүүгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ногоон зээлийн чадавхыг бэхжүүлэх, зээлийн сангийн урсгалыг чиглүүлэх эхлэлийн цэг болгон ашиглаж, дэмжих зорилготойгоор баталсан.

Хятадын Ардын банкны мэдээлснээр ногоон зээлийн үлдэгдэл 2013 оны 6 дугаар сарын сүүлчээр 4.85 их наяд юань байсан бол 2021 оны 3 дугаар сарын байдлаар 13 их наяд юань хүрч хурдацтай өсжээ. Өсөлтийн хувьд 2019 оноос хойш ногоон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд нь нийт зээлийн өсөлтөөс үндсэндээ өндөр хэвээр байна. Энэ нь банкууд ногоон зээлийн чиглэлээр хүчин чармайлтаа нэмэгдүүлсээр байгааг харуулж байна.

Ногоон бүтээгдэхүүний бодлого

"Ногоон бүтээгдэхүүний стандарт, баталгаажуулалт, шошгоны нэгдсэн тогтолцоог бий болгох тухай Төрийн зөвлөлийн ерөнхий газрын санал зөвлөмж"–д дурдсанаар: Ногоон бүтээгдэхүүний стандартыг сурталчлах, баталгаажуулах механизмыг бий болгож, ногоон санхүүжилт, ногоон үйлдвэрлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээжээ. Төрийн ногоон бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхээс гадна түүхий эдийн худалдааны зах зээлийг ногоон бүтээгдэхүүнээр өргөжүүлэх, худалдан авагчдыг ногоон бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх, ногоон захын бүтээн байгуулалтыг дэмжих зэрэг ажлуудыг чиг үүрэг болгон баталсан байна.

Сангийн яам болон Орон сууц, хот хөдөөгийн хөгжлийн яамнаас "Барилгын чанарыг сайжруулах туршилтын ажлыг дэмжих зорилгоор ногоон барилгын материалыг дэмжих Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай" мэдэгдэл гаргасан үүнд: Дахин ашиглах боломжтой бат бөх барилгын материал, ногоон эд анги зэргийг төрийн худалдан авалтын төсөлд ногоон барилгын материалын бүтээгдэхүүн болох чимэглэлийн материал, ус хэмнэлттэй, эрчим хүчний хэмнэлттэй барилга гэх мэт үйлдвэрлэлийн шинэ аргыг идэвхтэй ашиглах зэрэг багтана. Баримт бичгийг Чиндао, Фошан, Нанжин, Ханжоу, Шаосин, Хужоу зэрэг 6 туршилтын хотод хэрэгжүүлж байна. Чиндао, Фошан хот бүр ногоон барилгын материалын төрийн худалдан авалтад тавигдах техникийн шаардлагуудыг боловсруулж, ногоон бүтээгдэхүүний баталгаажуулалтын гэрчилгээг тавигдах шаардлагад оруулсан байна.

Хятад дахь ногоон зээлийн баталгаажуулалт

Хятадад ногоон зээлийн бүтээгдэхүүнийг баталгаажуулах нь санхүүгийн байгууллагуудын дотоод үнэлгээ болон гуравдагч талын үнэлгээг хамарсан хамтын хүчин чармайлт юм. Ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд Засгийн газар болон зохицуулах байгууллагууд ихээхэн дэмжлэг үзүүлж, ногоон зээл болон

бусад ногоон санхүүгийн бүтээгдэхүүний өсөлтийг дэмжих удирдамж, урамшууллыг нэвтрүүлсэн.

Хятадын Ардын банк (PBoC) зээлийн бодлого, макро зохистой үнэлгээнд ногоон зээлийг тусгаж, банкнуудыг ногоон багцаа өргөжүүлэх, ногоон зээлийн гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн боловч өөр өөр агентлагуудын байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) ил тод байдлын стандартуудын нарийн төвөгтэй, олон янз байдал нь гол сорилт хэвээр байна

Эдгээрийг шийдвэрлэхийн тулд Хятад Улс гуравдагч этгээдийн магадлан итгэмжлэлийн агентлагуудыг уриалахыг дэмжсээр ирсэн ба эдгээр агентлагууд нь ногоон зээлийн төслүүдийг хараат бусаар, байгаль орчны стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулж ногоон санхүүжилтийн найдвартай байдлыг дээшлүүлдэг. Энэхүү гуравдагч этгээдийн оролцоо нь үнэлгээний үйл явцын ил тод байдал, найдвартай байдлыг хадгалахад тусалдаг.

Ерөнхийдөө Хятадын банкнууд ногоон зээлийн дотоод баталгаажуулалт хийж байгаа ч олон улсын стандартыг дагаж мөрдөх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүний найдвартай байдлыг сайжруулахын тулд гуравдагч талын баталгаажуулалтын агентлагуудын оролцоог улам бүр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Баталгаажуулалтын гэрчилгээ олгох байгууллагууд

Хятадад ногоон бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагууд баталгаажуулалтын тусгай зөвшөөрлийг Хятадын захиргааны чанарын хяналтын ерөнхий газар (AQ-SIQ) болон Үндэсний итгэмжлэлийн зохицуулах төв (CNCA) зэрэг төрийн зохицуулалтын байгууллагуудаас авдаг. 2022 оны 2 дугаар сарын байдлаар ногоон бүтээгдэхүүний баталгаажуулалтын 68 байгууллага байгаагаас 62 нь ногоон бүтээгдэхүүний баталгаажуулалтын тусгай зөвшөөрөл авч ногоон барилгын материалын бүтээгдэхүүн, хүргэлтийн савлагаа болон цахилгаан, электрон бүтээгдэхүүн зэргийг гэрчилгээжүүлэх эрхтэй байна.

Хятад Улс 2022 оны 2 дугаар сарын байдлаар:

Ногоон барилгын материалын бүтээгдэхүүнтэй холбоотой нийт 1,132 ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ

Хүргэлтийн савлагаа, цахилгаан, электрон бүтээгдэхүүн дэх аюултай бодисын хязгаарлалттай холбоотой 15,535 ногоон гэрчилгээ олгосон байна.

Ногоон бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн үйл явц (90 хоногоос хэтрэхгүй)

<http://cx.cnca.cn/CertECloud/institutionBody/externalAuthenticetionGreenList?&showMode=1>

Энэ сайт дээр одоогоор хүчинтэй Хятад Улс дахь ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ олгодог байгууллагуудын жагсаалт харагдана.

Баталгаажуулалтын өргөдөл

Эхний үзлэг шалгалт

Бүтээгдэхүүний дээжээс авах хяналт шалгалт

Баталгаажуулалтын үр дүнг батлах, үнэлэх үйл явц

Баталгаажуулалтын дараах хяналт

Эх сурвалж: https://www.icasiso.com/cprz/productdetail_157.shtml

ДҮГНЭЛТ

- Ногоон зээлийн баталгаажуулалт нь хариуцлагатай хөрөнгө оруулалт хийх гэж буй хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, мөн ногоон мөнгө угаалтын эрсдэлээс хамгаалдаг давуу талтай. Харин улс орны хэмжээнд тус баталгаажуулалтыг нэвтрүүлснээр хөрөнгө оруулагчдын итгэлийг бий болгож гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн хоёрдогч болон гуравдагч талын баталгаажуулалт хийгддэг болсноор эх үүсвэр татахад болон өндөр хэмжээтэй зээл хүсэгчийг найдвартайгаар баталгаажуулах боломжтой болох юм.
- Олон улсын хэмжээнд баталгаажуулалтын 4 төрөл байдаг ба Монгол Улсад санхүүгийн байгууллагууд дотоодын баталгаажуулалтыг хийдэг ба тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах амлалтаа биелүүлэхийн тулд хөрөнгө оруулалт татах шаардлагатай байгаа тул баталгаажуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай. Манай улсад баталгаажуулалтын төрлүүд, мөн зохицуулалттай этгээдийн нөхцөл байдлаас дүгнэхэд хэрэгжүүлэх тохиромжтой хувилбар нь хоёрдогч талын санал болно.
- Хятад, Япон Улсуудын хувьд Засгийн газраас баталгаажуулалтын удирдамж, журмыг баталсан байдаг. Хятад Улсын хувьд ногоон зээлийн эх үүсвэрийн шаардлага, төрлөөс хамаарч дотоодын, хоёрдогч этгээдийн санал, гэрчилгээжүүлэлт, гуравдагч талын баталгаажуулалтыг ашиглаж байна. Харин Япон Улсын хувьд ногоон зээлийн удирдамж боловсруулсан ба хоёрдогч талын санал, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт, оноожуулалтыг аргыг ашигладаг байна. Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг нь ногоон зээлийн баталгаажуулалтад хяналт, зохицуулалтын чиг үүрэгтэй оролцдог байна.
- Ногоон зээлийн баталгаажуулалтын компаниуд нь тогтвортой санхүүгийн зах зээлд ил тод байдал, итгэлцлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Баталгаажуулалтын компаниудыг хүлээн зөвшөөрөгдсөн байгаль орчны мэргэжлийн байгууллагууд мэргэшүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг дагаж мөрдүүлснээр баталгааг хангадаг хангадаг.
- Олон улсын туршлагаа ногоон зээлийн баталгаажуулалтын тал дээр Санхүүгийн зохицуулагч байгууллагууд шууд оролцдоггүй ч бодлогын болон хөндлөнгийн хяналтыг сайжруулахаар зорьж байна. Иймээс цаашид баталгаажуулалтын байгууллагуудыг дэмжих бодлого мөн хөндлөнгийн хяналтын аргачлал боловсруулах шаардлагатай байна.

САНАЛ

- Монгол Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах амлалтаа биелүүлэх, НҮБ-ийн 17 зорилтыг хэрэгжүүлэхэд нилээд хэмжээний санхүүжилт шаардлагатай байна. Тус санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд санхүүгийн зах зээлийн оролцогчын оролцоо чухал ба ногоон санхүүжилтийн чиглэлээр хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгчдийг татахын тулд тэдгээрийн итгэлийг бий болгох хөндлөнгийн баталгаажуулалтын механизмыг нэвтрүүлэх шаардлагатай байна.
- Баталгаажуулалтын үйл ажиллагааг амжилттай эхлүүлэхийн тулд мэдээллийн нэгдсэн санг амжилттай үүсгэх, баталгаажуулалтын байгууллагуудыг зах зээлд нэвтрүүлэх хэрэгцээ байна.
- Баталгаажуулалтын механизмд Санхүүгийн зохицуулах хороо бодлогын болон хөндлөнгийн хяналтын байдлаар оролцох нь тохиромжтой. Мөн ногоон зээлийн удирдамжийг боловсруулах шаардлагатай байна.

Одоогийн байгаа нөхцөл боломжийг ашиглаж баталгаажуулалтын механизм бий болгох боломжууд:

1. БОАЖЯ-ны Ногоон гэрчилгээ авсан аж ахуйн нэгжүүдэд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхэлж байгааг нь урамшуулах хөшүүргийн тогтолцоо бий болгох. Өнөөдөр хэрэгжиж байгаа зээлийн бодлогоор БОАЖЯ-наас олгогдсон гэрчилгээтэй ААН аливаа зээлийг шалгуургүйгээр авах зохицуулалт байхгүй. Иймд БОАЖЯ-наас холбогдох журамд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа ба үүнд Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороо ажлын хэсэгт оролцон ажиллах.
2. Байгаль орчны аудитыг аливаа төсөл, үйл ажиллагаа эхлэхэд болон гүйцэтгэлийн шатанд байгаль орчны стандарт, дүрэм журмыг баримталж байгаа эсэхийг баталгаажуулах зорилготой хийдэг. Байгаль орчны аудитын эрх бүхий байгууллага ногоон төсөл, бүтээгдэхүүнийг тодорхойлох зохицуулалтгүй. Иймд байгаль орчны аудитыг санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн орчныг үүсгэх.
3. ТоС холбооноос ногоон зээлийн баталгаажуулахаар зорьж байгаа SOGE платформд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанк дэмжиж ажиллах.
4. Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи бүх ангиллын зээлийг баталгаажуулах гэхээсээ илүү одоогоор хөгжиж байгаа ногоон барилга, эрчим хүчний хэмнэлт зэрэг ангиллуудыг алхам алхмаар хөгжүүлэх хэрэгтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Danske Bank Group. “Green Finance Framework.” 2022. Available at: <https://danskebank.com/-/media/danske-bank-com/pdf/investor-relations/debt/green-bonds/danske-bank-green-finance-framework-november-2022.pdf>
- Loan Market Association. “Green Loan Principles.” 2023. Available at: <https://www.lma.eu.com/guides/green-loan-principles>
- Loan Market Association. “Sustainability-Linked Loan Principles.” 2023. Available at: <https://www.lma.eu.com/guides/sustainability-linked-loan-principles>
- World Bank. “What You Need to Know About Green Loans.” 2021. Available at: <https://www.worldbank.org/en/news/feature/2021/10/04/what-you-need-to-know-about-green-loans>
- Ministry of the Environment Japan. “Linked Bond Guidelines Green Loan and Sustainability Linked Loan Guidelines.” 2022. Available at: <https://www.env.go.jp/content/000128193.pdf>
- UN Global Compact. “Does japan need a sustainable finance taxonomy?” 2023. Available at: <https://www.unpri.org/download?ac=18224>
- Financial Services Agency of Japan. “Building A Financial System that Supports a Sustainable Society” 2021. Available at: <https://www.fsa.go.jp/en/news/2021/20210618/04.pdf>
- Financial Services Agency of Japan. “The Expert Panel on Sustainable Finance, Financial systems that open up a new sustainable society” 2021. Available at: <https://www.fsa.go.jp/news/r4/singi/20220713/02.pdf>
- Political Bureau of the CPC Central Committee. “Introduction to Green Product Certification.” 2018. Available at: http://www.fjsec.com/upload/content/file/2020/20200923111105_1845.pdf
- Shangai Ingeer Certification Assessment Co. “Green Product Certification” 2024. Available at: https://www.icasiso.com/cprz/productdetail_157.shtml
- Zhong Lun. “Green Finance Framework and Financial Instruments in China.” 2024 Available at: <https://www.zhonglun.com/research/articles/8719.html>
- United Nations. “Brundtland Report.” 1987. Available at: <http://www.un-documents.net/our-common-future.pdf>
- Asian Development Bank. “Technical assistance consultant’s report – green loan lifecycle review & recommendations” 2024.
- Тогтвортой байдлын зөвлөл. “Монгол Улсын ногоон таксономи.” 2019. Эх үүсвэр: <https://www.toc.mn/publication/mongol-ulsyn-nogoon-taksonomi>
- Монгол Банк, Санхүүгийн Зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци. “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи” 2023. Эх үүсвэр: <https://www.toc.mn/publication/sdg-finance-taxonomy>
- Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо. “Тогтвортой, ногоон санхүүжилт Монгол Улсад.” 2021. Эх үүсвэр: <http://www.frc.mn/resource/frc/File/2021/03/31/mmk7znq41402gnut/PPT6-%20Nandin-Erdene%20.pdf>
- Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо. “Монголын Ногоон Санхүүгийн Корпораци.” 2024. Эх үүсвэр: <https://www.toc.mn/project/mongolyn-nogoon-sankh-giin-korporaci>
- Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо. “Ногоон бондын удирдамж.” 2021. Эх үүсвэр: <https://www.toc.mn/publication/green-bond-guideline>
- Засгийн газар. “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр.” 2023. Эх үүсвэр: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532581246631&showType=1>

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Цуврал №50

Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ

Санхүүгийн салбарыг хиймэл оюун ухаан, их хэмжээний өгөгдөл зэрэг технологийн олон төрлийн хөгжил дэвшил нь эрчимтэйгээр өөрчилж байна.



Хиймэл оюун ухаанд суурилсан залилан илрүүлэлт ба аюулгүй байдал

Сэжигтэй гүйлгээг бодит цаг хугацаанд илрүүлж, зогсооход тусалж байна.

Зээлийн автомат боловсруулалт ба зээлийн оноо тогтоох

Хэрэглэгчийн орлого, зээлийн түүх, төлбөрийн сахилга бат зэрэг өгөгдлийг задлан шинжилж, зээлийн эрсдэлийг тооцож шударга, үр ашигтай үнэлгээ хийхэд тусалж байна.



Гүйлгээний урьдчилсан таамаглал бүхий дүн шинжилгээ

Хэрэглэгчийн гүйлгээний мэдээлэлд үндэслэн ирээдүйн хэрэглээний хэв маягийг урьдчилан таамаглаж байна.

Автоматжуулсан нийцэл шалгалт ба эрсдэлийн менежмент

Хууль, журамтай уялдуулан өгөгдлийг байнга шалгаж, зөрчлийг автоматаар илрүүлж байна.



Хувь хүнд тохируулсан санал, зөвлөмжүүд

Өмнөх гүйлгээ, хадгаламж, хэрэглээний хэв маягт үндэслэн тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, зөвлөмжийг санал болгож байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО


Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Цуврал №50

Хиймэл оюун ухаан гэж юу вэ?

Хиймэл оюун ухаан (ХОУ) буюу Artificial Intelligence (AI) нь хүн шиг сэтгэх, суралцах, шийдвэр гаргах чадвартай машин, програм хангамж юм.

Хиймэл оюун ухаан




1950–1970

Нейрон сүлжээ

(Neural network)

Хүний тархитай төстэй. Оролт (өгөгдөл) аваад, дүгнэлт гаргадаг.

Жишээ: Зураг дээрх тоо ямар цифр вэ гэдгийг танина.



1980–2010

Машин сургалт

(Machine learning)

Компьютер өгөгдөлд өөрөө суралцаж, дараа нь таамаг гаргаж чадна.

Жишээ: Банк хүнд зээл олгох уу, үгүй юу гэдгийг өгөгдөл дээр үндэслэж шийднэ.



2011–2020

Гүнзгий сургалт

(Deep learning)

Нарийн, төвөгтэй мэдээллийг ойлгож, илүү нарийвчилсан дүгнэлт гаргаж чадна.

Жишээ: Хүний яриаг ойлгоод хариулт өгөх; Нүүр царай таних.



2021–с хойш

Үүсгэх хиймэл оюун ухаан

(Generative AI)

Өгөгдөлд үндэслэн шинэ зүйл бүтээж чадна.

Жишээ: Танилцуулга бэлтгэх; Зураг зурах; Видео, дуу үүсгэх.

Хиймэл оюун ухаан нь бидний эргэн тойронд аль хэдийн байр суурь эзэлж, хэрэглээний салшгүй хэсэг болжээ.



NETFLIX



ChatGPT



amazon

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗӨӨЛИЙН МӨДӨӨ

ОЛОН УЛСЫН ТООЦООНЫ БАНК (BIS) ЗАСГИЙН ГАЗРУУДАД ӨРИЙН “ЗОГСолтгүй” ӨСӨЛТИЙГ ХЯЗГААРЛАХЫГ УРИАЛЖ БАЙНА .



Олон улсын тооцооны банк (BIS)-ны ерөнхий захирал Агустин Карстенс хэлэхдээ, улс орнуудын өр хэт нэмэгдэж байгаа нь эрсдэл дагуулж байгаа тул одооноос эхлэн төсвийн сахилга батыг сэргээх хэрэгтэй гэж мэдэгдэв.

Өнгөрсөн хугацаанд хүү бага байсан тул засгийн газрууд зарлагаа нэмэх боломжтой байсан. Харин одоо хүү өссөн тул өнөөдрийн бодлого цаашид тогтвортой биш болж байна.

Хэрэв засгийн газрууд үргэлжлүүлэн их хэмжээний өр тавивал: инфляц өсөх, валют сулрах, санхүүгийн тогтворгүй байдал бий болно. Карстенс мөн төв банкнууд бүх зүйлийг шийдэж чадахгүй, засгийн газрууд өөрсдөө татвар, зарлагаа хянах төлөвлөгөө гаргах ёстой гэж мэдэгджээ.

Эх сурвалж: www.reuters.com

АНУ-ЫН ИНФЛЯЦЫН МЭДЭЭ ДЭЛХИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨСГӨЖ, АМ.ДОЛЛАРЫН ХАНШ УНАВ.

5 дугаар сарын 13-ны Мягмар гарагт АНУ-ын хэрэглэгчийн инфляц хүлээлтээс бага гарсан мэдээний дараа АНУ-ын хувьцааны гол индексүүд өсөж, ам.доллар сулрав. Европын хувьцаанууд дөрөв дэх өдрөө дараалан өссөн бол дэлхийн хөрөнгийн зах зээл ч мөн нэмэгдсэн байна.

АНУ, Хятад хоёр худалдааны дайнаа 90 хоногоор хойшлуулах тохиролцоонд хүрсэн нь хөрөнгө оруулагчдын хувьцаа, криптовалют, түүхий эдэд чиглэсэн сонирхлыг сэргээсэн.



АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчоо мэдээлэхдээ, 4 дүгээр сард хэрэглээний үнийн индекс 0.2%-иар өссөн бөгөөд жилийн инфляц 2.4%-иас 2.3%-д буурсан байна. Энэ нь шинжээчдийн сарын 0.3%-ийн өсөлт, жилийн 2.4%-ийн өсөлтийн таамгаас бага байсан.

Эх сурвалж: www.reuters.com

JPMORGAN: ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД АНУ-ЫН ЗАХ ЗЭЭЛЭЭС ТАТГАЛЗАЖ, ЕВРОП РУУ ШИЛЖИЖ БАЙНА.

JPMorgan-ийн судалгаагаар дэлхийн 45 орны хөрөнгө оруулагчдын дунд “Америкийг зар” (sell America) гэсэн хандлага нэмэгдэж олонх нь 2025 онд Европын хувьцаа хамгийн их өсөлттэй байна гэж үзжээ. АНУ-ын эдийн засгийн төлөв, инфляц, тариф, бодлогын тодорхой бус байдал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж байна.

Европын зах зээл энэ жил 7% өссөн бол АНУ-ын S&P 500 1% орчим унажээ. Гэсэн ч Wall Street-ийн зарим шинжээчид АНУ-ын зах зээл урт хугацаандаа давамгайл хэвээр байх төлөвтэй гэж анхааруулж байна.



Түүнчлэн тарифын эрсдэл, Хятадын болон Европын Холбоотой хийж буй хэлэлцээ, АНУ-ын өрийн зах зээлээс хөрөнгө гадагшлах хандлага зэрэг нь зах зээлд тогтворгүй байдал үүсгэж байна. JPMorgan компанийн тооцоогоор, гадаадын хөрөнгө оруулагчдын АНУ-ын хөрөнгөөс ердөө 0.5%-ийг алт руу шилжүүлэхэд л алт жилд 18%-иар өсөж, 2029 он гэхэд унц нь 6,000 ам.доллар хүрч магадгүй аж.

Эх сурвалж: www.businessinsider.com

ЕВРОПЫН ХУВЬЦААНЫ ХАНШ ӨСӨВ, АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ДОНАЛЬД ТРАМП ЕВРОПЫН ХОЛБООНД БАРААНД НОГДУУЛАХ 50 ХУВИЙН ТАРИФЫГ ХОЙШЛУУЛЛАА.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Европын холбооны бараанд ногдуулах 50%-ийн тарифыг 6 дугаар сарын 01-нээс хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан ч 7 дугаар сарын 09 хүртэл хойшлуулах шийдвэр гаргасны дараа Европын хувьцааны зах зээл өсөв. Энэхүү алхам нь Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лейентэй хийсэн утасны ярианы үр дүн бөгөөд



талууд худалдааны хэлэлцээг үргэлжлүүлэхээр тохиролцсон байна. Үүний улмаас хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн бөгөөд Германы DAX индекс 1.5%, Францын CAC 40 индекс 1%-иар өссөн бол АНУ-ын фьючерсүүд ч мөн нэмэгдсэн.

Эх сурвалж: www.apnews.com


WORLD FINANCE

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр


S&P 500 / ^GSPC/

5,802.82 -39.19 (-0.67%)



Nikkei 225 / ^N225/

37,728.85 +200.17 (+0.57%)



FTSE 100 / ^FTSE/

8,718.00 -22.29 (-0.27%)



NASDAQ Composite (^IXIC)

18,737.21 -188.89 (-1.00%)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ЁС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

АВЛГАТАЙ ТӨМЦЭХ ГАЗАР